

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх

Статистикийн хэлтсийн товч түүх.

2000.10.26

Зуунмод

Миний бие өөр ажилд шилжих болсон учир аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийг бие даан байгуулах үед хэлтсийн даргаар томилогдон ажиллаж байсны хувьд товч боловч хэдэн өгүүлбэрийг нийлүүлэн дараагийн хүнийг баяжуулж байхыг бэлгэдэж сууна.

Монгол улсын Статистикийн тухай хууль **1997** оны **6**-р сарын **5**-нд шинэчлэгдэн батлагдаж, мөрдөгдөж эхэлсэн юм. /Статистикийн анхны хууль 1994 онд батлагдсан/

Статистикийн албыг хуулийн дагуу хараат бус, бие даасан үйл ажиллагаатай байх зарчмыг үндэслэн аймгийн засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийг Аймгийн Засаг даргын 1997 оны **198**-р захирамжаар мөн оны 7-р сарын 25-наас эхлэн **6** хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан билээ.

Хэлтсийн даргыг Монгол улсын Үндэсний Статистикийн газрын дарга томилж баталдаг. Харин хэлтсийн ажилтнуудыг хэлтсийн даргын тушаалаар ажилд томилдог журамтай болов.

Хэлтсийн ахлах мэргэжилтнээр - Ж.Отгончулуун

Статистикчаар - Д.Аюуш

- С.Дуламсүрэн

Улсын байчаагчаар - С.Ундрахбаяр

Операторчноор - С.Энхбаатар нар анх ажилд томилогдож байлаа.

Хэлтсийн хамт олон албан ёсны Статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан зарчмын дагуу явуулахад бүхий л ажлаа чиглүүлж байв.

Манай хамт олон өнгөрсөн **3** жилд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- Хэлтсийн хамт олны ажиллах нөхцөлийг хангаж, тэднийг ажлын гол хэрэгсэл компьютер, принтерээр хангаж, хүчин чадлыг нэмэгдүүлж мөн ширээ сандлыг шинэчлэв.
- Сумдын Засаг даргын орлогч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд анхаарч орлогчдыг 1998 онд 3 үе шаттайгаар компьютерийн сургалтанд бүрэн хамруулав.

- Статистик мэдээ гаргалт түүний хамралтыг нэмэгдүүлэн үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор **Борнуур, Эрдэнэ** сумдад Засаг даргын орлогч нарыг оролцуулан бүсчилсэн үзүүлэх сургууль семинар зохион байгуулж **"Албан даалгавар"** гарган ажиллав.
- Сумдын орлогч нарын ажлыг идэвхжүүлэх зорилгоор уралдааны болзол гарган биелэлтийг нь тооцон ажиллалаа.
- Сумдад Монгол улсын Статистикийн тухай хуулийг багийн Засаг дарга, орлогч нарын тоогоор олшруулан хүргүүлэхээс гадна **Улсын графикт мэдээ тайлангийн альбомыг** 2 удаа шинэчлэн хүргүүлэв. Мөн аймгийн эдийн засаг, нийгмийн жил бүрийн танилцуулгыг сумдын удирдлагуудыг мэдээллээр хангах зорилгоор **жил бүр** олшруулан хүргүүлэх ажлыг хэвшүүлээ.
- Улсын графикт мэдээ тайлангийн ирцийг улирал тутам гарган сумдад хүргүүлж ажилласан нь мэдээний тасалдал хожимдол багасах үндэслэл болсон.
- Аймгийн удирдлага, хэрэглэгчдийг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангах зорилгоор аймгийн эдийн засаг, нийгмийн сүүлийн **12** жилийн үзүүлэлтүүдээр дэлгэрэнгүй судалгаа гаргаад байна. /Цаашид аймгийн хэмжээний товхимол гаргах зорилготой юм/
- Аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүнийг олон улсын аргачлалаар 1997 оноос анх удаа тооцож эхэлснээс хойш энэ ажлыг жил бүр тогтмолжууллаа.
- Хэлтэс байгуулагдсанаас хойш ҮСГ-тай хамтран орон нутагт дараахь судалгаануудыг явууллаа.
 1. Амьжиргааны түвшиний судалгаа 1998 онд /3 суманд/
 2. Эрүүл мэндийн нөхөн үржихүйн судалгаа 1998 онд /10 суманд/
 3. Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа 2000 онд /3 суманд/
 4. Цаг ашиглалтын судалгаа 2000 онд /2 суманд/
 5. Хүүхэд хөгжил судалгаа 2000 онд /9 суманд/
 6. Өрхийн аж ахуйн орлого, зарлагын судалгааг 96 өрх дээр хийж байна.
- Хэлтсийн хамт олон улсын чанартай дараахь тооллогуудыг хийж, дүн мэдээг нэгтгэн гаргалаа.
 - А. Мал тэжээвэр амьтдын улсын тооллогыг /жил бүр/
 - Б. Аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллогыг 1998 онд

В. Хүн ам, орон сууцны улсын тооллогыг 2000 онд хийж урьдчилсан дүнг гарган ҮСГ-т материалаа амжилттай тушаав.

- Хэлтэс байгуулагдсанаас хойш хэлтсийн хамт олон, сумын Засаг дарга, орлогчид болон албан ёсны статистикийн мэдээлэгч, ня-бо нараас ажил үүргээ чанартай гүйцэтгэсэн **192** хүнийг төрийн одон медаль, ҮСГ-ын шагнал, Бүртгэл Статистикийн тэргүүний ажилтан цол, тэмдэг, Аймгийн Засаг дарга, хэлтсийн шагналаар шагнаж урамшууллаа.
- ◆ Монгол улсын ҮСГ-ын Хүндэт дэвтэрт - Д.Аюуш /хэлтсийн статистикч/
- ◆ Алтан гадас одонгоор - Д.Аюуш /хэлтсийн статистикч/
- ◆ Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан цол, тэмдгээр

Ц.Батболд - /Аймгийн Засаг дарга/

Ж.Отгончулуун /хэлтсийн ахлах статистикч/

С.Доржбаатар /Баян-Өнжүүл сумын ЗДО/

С.Сүхээ /Баянцогт сумын Засаг дарга/

Л.Насанжаргал /Архуст сумын ЗДО/

Зөвхөн хэлтсийн шагналаар **40** хүнийг шагнасан төдийгүй, Хүн ам, орон сууцны улсын тооллогод сайн ажилласан аймаг, сумын комиссын болон түр товчооны гишүүд, тоологч, шалгагч **124** хүнийг ҮСГ-т тодорхойлж мөнгөн шагналаар шагнуулав.

- Хэлтсийн бүтэц зохион байгуулалт, мэдээ дамжуулалт, тархалтын байдлыг харуулсан схемүүдийг гаргасан.
- Хэлтсийн дарга 1998 оны 6-р сард Статистикийн үйл ажиллагааг орон нутагт хэрхэн удирдан зохион байгуулж байгаа тухай Монгол улсын ҮСГ-ын даргын зөвлөлд сонсгол тавьж хэлэлцүүлэв. Даргын зөвлөлөөс хэлтсийн хамт олны ажлыг өндөр үнэлж, хийж бүтээж байгаа ажлуудыг бусад аймгуудад сурталчилж яриулах нь зүйтэй гэж шийдсэн юм. Аймгуудын Статистикийн хэлтсийн дарга нар бидний сонсгол тавихад бэлтгэсэн бүх материалыг олшруулан авч байв.
- Орон нутагт Статистикийн байгууллагын ажлыг хэрхэн удирдан зохион байгуулж байгаагаа ҮСГ-т ирсэн гадаадын зочид төлөөлөгч нарт **12** удаа танилцуулав.
- Манай хэлтсийн ажлын туршлагыг **УБ** хотын Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга, ажилтнууд болон **Сүхбаатар дүүрэг, Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэр, Хэнтий** аймгийнхан ирж үзэж танилцан, харилцан саналаа солилцсон болно.

- Хэлтсийн ажилтан н. Дуламсүрэнг орон сууцанд оруулав.
- Монгол улсад Статистикийн алба байгуулагдсан 11-р сарын 24-ний өдрөөр аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагуудын дунд Статистикийн хэлтсийн нэрэмжит "Шатар", "Биллъярд"-ын тэмцээнүүдийг жил бүр уламжлал болгон тогтмол явуулж байна.

Манай хэлтсийн хамт олон хамтач бүтээлч үйл ажиллагааныхаа үр дүнгээр системийнхээ хэмжээнд 1998, 2000 онуудад ажил үйлсээрээ **тэргүүн** байрт шалгарлаа. Хэлтэс бие дааж үйл ажиллагаа явуулах болсон гурван жилийн хугацаанд 2 удаа системдээ тэргүүлнэ гэдэг тийм ч амаргүй нь хэн бүхэнд ойлгомжтой.

Шинэ дарга болон хэлтсийн хамт олондоо хүрсэн амжилтаа бууруулахгүй байхыг хүсэхийн ялдамд та бүхэнд, та бүгдийн гэр бүл, ах дүүс, найз нөхөд, ажил төрлийн холбоотой бүх нөхдөд эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Статистикийн ажил нь нийгмийн он цагийн түүхийг тоон утгаар нь бичиж байгаагаараа агуу учир түүх бичигчдийн өлзий хийморь мөнхөд бадартугай.

Товч түүх бичсэн:

Хэлтсийн дарга

П.Цэрэн